

**УУЛ УУРХАЙН ЯАМНЫ 2015 ОНЫ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
1	Улсын Их Хуралд хэлэлцэх хууль, УИХ-ын бусад шийдвэрийн өслийг талаар төрийн болон төрийн байгууллага, олон нийтийн үзэс саналаа илэрхийлэх бололцоо нөхцлөөр хангах	Яамны цахим хуудсаар хууль, бусад шийдвэрийн өслүүдийн талаар иргэдээс санал үзэж авах, санал асуулга явуулах нөхцлийг бүрдүүлнэ	<p>Яамны вэб сайтын Эрх зүй цэс дотор Хуулийн төсөл гэсэн үлэгт Хууль, дүрэм журмын төслүүдийг байршуулж саналыг info@mm.gov.mn хаягаар хүлээн авч байна mm.gov.mn сайтад хуулийн төсөл, журамд иргэдээс санал авч ажиллаж байна.</p> <p>2014 онд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль", Үгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль", "Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-аар батлуулсан. Шинээр гарсан хуулиудтай нийцэн зарим журам дүрмийг шинээр боловсруулж Засгийн газраар батлуулах ажил яам, агентлагын үйлдвэрийн хийгдэж байна.</p> <p>Яамны цахим хуудсанд Шилэн дансны мэдээллийг байршуулж бие даасан цэстэй байна.</p> <p>-Шилэн дансны мэдээллийг татаж авах, хэвлэх боломжтой.</p> <p>-Тодруулга өгөх албан тушаалтны нэр, холбоо барих хаягийг цахим хуудсанд байршуулсан байна.</p>
		Бодлогын баримт бичүүд болон тухайн жилд хариуцан хэлэлцүүлэх асуудлын	Уул уурхайн яамнаас Засгийн газрын хуралдаанд 10 дугаар сарын 30-ны байдлаар нийт 56 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна. Засгийн газрын

		<p>жагсаалтад орсон хууль, УИХ-ын шийдвэрийн өсөлд холбогдох яам, агентлаг иргэд, ТББ-ын саналыг авах, хэлэлцүүлгийг ил тод нээлттэй хэлбэрээр хийх</p>	<p>хуралдаанд танилцуулсан болон шийдвэрлэсэн асуудлуудыг бүх яамдаас саналыг авсан болно. Мөн дараах 2 асуудлаар холбогдон Тбс байгууллага, мэргэжлийн холбоодоос санал албан бичгээр болон яамны вэб сайтаар саналыг авч тусгасан. Шийдвэрийг тухайрбнь Яамны вэб сайтанд байршуулан ажиллаж байна. www.mm.gov.mn</p>
2	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд байгууллага өлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэх</p>	<p>Салбарын хэмжээнд “Авлигын эсрэг хамтдаа” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулна.</p>	<p>Уул уурхай, газрын тосны салбарын хэмжээнд “Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ”-ний хэлэлцүүлгийг Уул уурхайн яам, Дэлхийн банкны уул уурхайн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамтран Улаанбаатар хот болон Сүмнөговь, Төв, Дорноговь аймгуудад зохион байгуулаад байна. Хэлэлцүүлэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аймаг, сумдын 150 орчим өлөөлөл, уул уурхайн 60 орчим компаниуд болон иргэний нийгмийн байгууллагын өлөөлөл оролцсон байна. Одоо 2015.11.17-ны өдөр Улаанбаатар эцсийн хэлэлцүүлгийг зохион байгуулхаар ажиллаж байна. Үүний үр дүнд Газрын тосны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан уг хуулийн 7.1.13-т “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн өгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээний загвар”-ыг Засгийн газар батлахаар заасны дагуу гэрээний загварын өслийг “Гэрээний загвар батлах тухай” Засгийн газрын тогтоолын өслийн хамт боловсруулан Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Уул уурхайн салбарын гэрээний загварыг 2015 ондоо багтааж батлуулахаар ажиллаж байна.</p>

		Ажилтнуудын дунд яриа танилцуулга, мэдээлэл хийх, хэвлэмэл хуудас, гарын авлага материал тараах, яамны цахим хуудас, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулах	Яамны албан хаагчдын дунд хаагчдад “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдэг” болон “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг өрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиар сургалт явуулсан. Сургалтыг АТГ-ын Хяналт шалгалт, үн шинжилгээний хэлтсийн ажилтан комиссар Н.Мөнхбаяр явуулж, гарын авлага материал өгсөн. Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалт, семинарт яамны ЭБАТ болон яамны албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Сургалт семинарийн үеэр өгсөн гарын авлага материалыг яамны удирдлагуудад танилцуулж өгсөн. Долоо хоног бүрийн 5 дахь өдөр бүр нийт ажилтнуудад сургалт, мэдээллийг өгдөг. Мөн гарын авлага тараах материалуудыг гаргаж мэдээллийн самбарыг тогтмол байршуулж байна.
3	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй санал солилцох	Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн өслийг яамны цахим хуудас болон Е-оффис, мэдээллийн самбарт байрлуулж мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах. Бодлогын баримт бичгийн болон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч үлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх	Уул уурхайн яамнаас боловсруулж батлуулсан бодлогын баримт, дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн өслүүдийг www.mm.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллаж байна. Яамны вэб сайтын Эрх зүй цэс дотор Хуулийн төсөл гэсэн үлэгт Хууль, дүрэм журмын төслүүдийг байршуулж саналыг info@mm.gov.mn хаягаар хүлээн авч байна.
4	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод,	Хяналт-шинжилгээ дотоод аудитын ажлыг төлөвлөгөөг	Уул уурхайн яамны 2015 оны “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г боловсруулан Уул уурхайн сайдын

нээлттэй байдлыг хангах	хэрэгжүүлж ажиллана	2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар тушаалаар батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Агентлаг, газар хэлтсүүдийн 2014 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийж Уул уурхайн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарьт 2015 оны 4 дүгээр сард хүргүүлсэн.
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон бусад тайлан мэдээг цахим хуудсанд байршуулах	2015 оны 7 дугаар сарын 17-ны өдөр 2015 оны хагас жилийн байдлаарх хяналтад авсан Хууль тогтоомжийн 254 шийдвэрийн 391,3 заалтд ; “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 2, 4, 9 үдээр зорилтын 6 арга хэмжээ; Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд үйл ажиллагааны өтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 54 зорилтын 12 7 арга хэмжээний биелэлтүүдийг төлөвлөгөөт хугацаандаа ЗГХЭГ-ын unelgee.gov.mn цахим сайтад шивж оруулсан.
	Төсвийн шууд захирагч болон яамны дотоод үүдийг менежерүүдийн үр дүнгийн гэрээний биелэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн аудитын тайлан, бусад хяналт шалгалт, ажлын хэсгийн тайлан мэдээг яамны цахим хуудас болон мэдээллийн самбараар олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар мэдээллэнэ.	Уул уурхайн яамны өрийн нарийн бичгийн дарга, Ашигт малтмалын газрын дарга, Газрын тосны газрын дарга, Менежерүүдийн үр дүнгийн гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээний нэгдсэн дүн, дүгнэлт, санал зөвлөмжийг удирдлагуудад танилцуулан тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2015 оны хагас жилийн байдлаар Уул уурхайн сайдын эрхлэх асуудлыг үрээний зорилт, арга хэмжээ, салбарын үйл ажиллагаа болон яамны удирдлагуудад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгүүдэд явц байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дүнг удирдлагуудад болон үх мэргэжилтнүүдэд яамны дотоод Эйбл програмаар хүргүүлсэн. Газрын тосны газрын 2013-2014 онд үйл

			ажиллагаанд дотоод аудитыг 2015 оныг эрд сарын 02-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатай хийж байгаа ба дүгнэлт нь гараагүй байна.
5	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, үүний т хувиарлалтыг олон нийтэд тухай бүр мэдээллэх	2015 оны өсөв, 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2016 оны жилийн төсвийн төслийг олон нийтэд тухай бүр мэдээллэж байх	2015 оны өсөв, 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2016 оны жилийн төсвийн төслийг Уул уурхайн яамны вейб сайтын “Шилэн данс”-д байршуулан олон нийтэд тухай бүр мэдээллэж байна.
		Жилийн эцсийн үүсвэр тайланг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээллэнэ.	Жилийн эцсийн санхүүгийн тайланг УУЯ -ны цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээллэсэн.
		Яамны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна.	Яамны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсын “Шилэн данс-д болон мэдээллийн самбарт байрлуулсан.
		Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсын нээн ажиллуулж төсөвтэй холбоотой бүх мэдээллийг байршуулан ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллана.	Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсын нээн ажиллуулж төсөвтэй холбоотой бүх мэдээллийг байршуулан ил тод, нээлттэй байдлыг хангаж ирүүлээд байна.
6	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	Яам, агентлагаас олгож байгаа зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гэх мэт бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт , түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, журмыг яам, агентлагын цахим хуудсанд байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэрэг ил тод нээлттэй байдлыг хангана.	Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл болон Газрын тосны болон газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон журам, зааврыг УУЯ-ны www.mm.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Өм яамны үүдний цахим дэлгэцэнд “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журам”-ыг байршуулж, иргэд олон нийтэд мэдээллийг тогтмол түгээж байна. Түүнчлэн 51-260631 дугаарын утсаар өдөр бүр тусгай зөвшөөрөлтэй холбогдсон аливаа асуултад шуурхай хариулт ажиллаж

			байна.
		Тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг тусгай зөвшөөрөл хүссэн иргэдэд ил тод нээлттэй байдлаар яам, агентлагын цахим хуудсанд байршуулж мэдээллэх боломжийг бүрдүүлнэ.	Тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай агуулах, ШТС-ын дүгнэлт, бүртгэлийн гэрчилгээний талаар мөн тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдийн талаар Газрын тосны газрын www.pam.gov.mn цахим хуудсанд тухай бүр шинэчлэн оруулж, нийтэд мэдээллэж байна.
		Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, үйлдвэрлэх ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг яам, агентлагын цахим хуудсанд байрлуулна. Газрын тосны хайгуул, олборлолтын чиглэлээр ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй Засгийн газраас байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг яам, агентлагын цахим хуудсанд ил тод нээлттэй байршуулна.	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг Газрын тосны газрын цахим хуудсаар дамжуулан улирал шинэчлэн мэдээллэж байна. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлийг 2015 онд 27 байгууллага, аж ахуйн нэгжид шинээр олгосон байна. 2015 онд Газрын тосны биеий худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 аж ахуйн нэгжид, Жижгэлэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 4 аж ахуйн нэгжид, Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох тусгай зөвшөөрлийг 12 аж ахуйн нэгжид, Шингэрүүлсэн шатдаг хийн тусгай зөвшөөрлийг 10 аж ахуйн нэгжид тус тус олгосон байна. Бүртгэлийн жагсаалтыг УУЯ-ны www.mm.gov.mn цахим хуудсанд байршуулсан - Газрын тосны хайгуул, олборлолтын тухайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг 2015 оны 3 дугаар сард шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд загварыг яамны цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээллэсэн болно.
7	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг үүнтэй танилцах боломжоор хангах	Сул ажлын байранд УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалтыг яамны цахим хуудсанд үндий	2015 онд 2 ажлын байрны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан Төрийн захиргааны удирдлагын газрын гадаад хамтын ажиллагааны хэлтсийн

		<p>нөөцийн ил тод байдал" гэсэн зэсэнд ил тод нээлттэй байршуулна.</p>	<p>мэргэжилтний ажлын байранд өдөс сонгон шалгаруулж, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилсон.</p> <p>Стратегийн бодлого, өлөвлөлтийн газрын дарга, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Түлшний бодлого, зохицуулалтын газрын дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын ажлын байрны захиалгын Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн дүгнэлт гаргуулан томилон ажиллуулж байна.</p>
		<p>Төрийн албан хаагчдад дараах сэдвээр сургалт явуулна.</p> <p>- Авлигын эсрэг хууль, Нийтийн албан хувийн ашиг сонирхлыг зохицуулах болон ашиг сонирхлын өрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол</p> <p>-Төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх сургалт</p> <p>-Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсронгуй болгох чиглэлээр сургалт</p>	<p>-Авлигын эсрэг хууль, Нийтийн албан хувийн ашиг сонирхлыг зохицуулах болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолын талаар сургалтыг АТГ-тай хамтран 2015 оны 01 дүгээр сарын 01 дүгээр сарын 09 -ний өдөр Уул уурхайн яаманд зохион байгуулсан. Сургалтыг АТГ-ын Хяналт-шалгалт үн шинжилгээний хэлтсийн ажилтан Н.Мөнхбаяр явуулсан.</p> <p>-Төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх сургалтыг Дэлхийн банкньөслөөр 2015 оны 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн сургалтын хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Санхүүжилтийн асуудлаас шалтгаалан сургалтыг үр хойшлуулсан. 11 үдэр сардаа багтаан зохион байгуулна. Сургалтын хөтөлбөрийг хавсаргав.</p> <p>-Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсронгуй болгох чиглэлээр Хууль зүйн яамтай хамтарсан сургалтыг Уул уурхайн яамны албан хаагчдад 2015 оны 3 дугаар сард зохион байгуулсан.</p>
8	Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажилчилгээ худалдан авах	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэглэлээр нийтэд зарлана.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдэгдэж, УУЯ-ны цахим хуудасд байршуулан, нэмээ өрчлөлт

	ажиллагааны ил тод байдлыг хангахуүнтэй танилцах боломжоор хангах	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна.	оруулах бүрд мэдээллэж ажиллаа. Тендерийн урилгыг яамны цахим хуудас болон Сангийн яамны цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүрд байрлуулж ажиллаж байна.
9	Албан хаагч үүргийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	Яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэгдэн батлагдсантай уялдуулан яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны стратегийн хөтөлбөрийг шинээр боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 үдээр тогтоолоор батлагдсан зааврын дагуу өөрийн албан хаагчдын ажлын байр/албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн ТНБД-ын тушаалаар баталж мөрдүүлнэ.	Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 402 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар “Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр-ийг батлуулсан. “Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-тэй уялдуулан яамны зохион байгуулалтын үүднээс үйл ажиллагааны стратегийг өөрийн нарийн бичгийн даргын 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 75 дугаар тушаалын хавсралтаар баталж мөрдөн ажиллаж байна.
		Албан хаагчдын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангана.	Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 46 дугаар тушаалаар Яамны зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан 59 ажлын байр/албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 75 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.
10	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн	Салбарын хэмжээнд авлигатай тэмцэх талаарх бус байгууллагууд хамтран	"Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ"-ний өслийг боловсруулах ажлын хүрээнд Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж

	дурын өдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	ажиллана. Салбарын хэмжээнд авлигаас урьчилан сэргийлэх талаар судалгаа авахүгдэлт гаргах ажлыг өрийн Т бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	байна. Уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ"-ний хэлэлцүүлгийг Уул уурхайн яам, Дэлхийн банкны уул уурхайн дэд үбэц, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамтран Улаанбаатар хот болонӨмнөговь, Төв, Дорноговь аймгуудад зохион байгуулаад байна. Хэлэлцүүлэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аймаг, сумдын 150 орчим өлөөлөл, уул уурхайн 60 орчим компаниуд болон иргэний нийгмийн байгууллагын өлөөлөл оролцсон 6 айна. Одоо 2015.11.17-ны өдөр Улаанбаатар эцсийн хэлэлцүүлгийг зохион байгуулхаар ажиллаж байна. Энэ арга хэмжээний Т бус байгууллагын төлөөллүүд оролцож санал солилцож гэрээний төсөлд саналаа тусган ажиллаж байгаа.
11	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, уг асуудлаар Авлигтай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтан ажиллуулна.	Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод тодорхой тусгах Авлигтай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалтад тасралтгүй хамрагдах Хувь үний нууцтай холбогдох мэдээллийг хадгалалт хамгаалалтыг бүрэн хангана.	Эрх үхий албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод гүйцэтгэх чиг үүргийг тусган хэрэгжилтээд хяналт таин ажиллаж байна.ӨМүр дүнгийн гэрээнд тусгай захиалгат бүтээгдэхүүнд тусгасан болно. Авлигтай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалтад бүрэн хамрагдсан. Албан хаагчдын ХАСХОМ-ийг нууцийн тэмдэг дарсан дугтуйнд хийж цагаан толгойвгийн дарааллаар жагсаалт гарган сейфэнд журмын дагуу хадгалж байна. Лац тэмдэгтэй болно. ЭБАТ нь нууцын баталгаа гаргуулсан болно
12	Ашиг сонирхлын өрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон хэрэгжүүлнэ.	Зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлнэ. Санал үзэлтийг хүлээн авч бүртгэл хөтөлж хэрэгжилтийн талаар хамт олонд тогтмол мэдээллэнэ.	Зөрчлийг яамны ЭБАТ бүртгэж авах бөгөөд одоогоор бүртгэгдсэн зөрчил байхгүй болно. Тендерийн үнэлгээний хороо болон ажлын хэсгийн гүүшээр томлогдох, шинжээчээр ажиллахад албан хаагчид ашиг сонирхлынөрчлийн тухай хуулийн дагуу тайлбар мэдэглийг тухайр бнь гаргуулан авч

			цахимаар болон цаасаар бүртгэж байна.
13	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулан мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулна.	Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6-д заасны дагуу мэргэжлийн өвлөгөө өгөх, байгууллагын удирдлагын өвшөөрснөөр багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх боломжтой бөгөөд энэ дагуу яамны Геологийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Алтанхуяг ШУТИС-ын Геологи, уул уурхай, газрын тосны сургуульд цагийн багш хийдэг бөгөөд өөр давхар ажил эрхэлдэг албан хаагч байхгүй болно. Төрийн албаны тухай хуулийг яамны цахим хуудсанд байршуулсан болно. Яамны хэмжээнд өрийн албаны тухай хуулийн дээрх заалтын давхар албан тушаал эрхлэхийг өвшөөрч байгаа болно.
14	Яамны удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	Уул уурхайн сайд, дэд сайд, ТНБД, яамны удирдлагуудаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангаж яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлууна.	Сар бүрийн сүүлчийн долоо хоногийн лхагва гаригт “Ил тод уул уурхай” хэвлэлийн хурлыг тогтмол зохион байгуулдаг. Уул уурхайн яам байгуулагдсанаас хойш дээрх хурлыг 34 удаа зохион байгуулсан. Энэ хурлын хэвлэлийн мэдээг УУЯ-ны вэб сайт, мэдээллийн самбар болон хэвлэл мэдээллийн бүхий л хэргэслээр олон нийтэд өргөнөөр мэдээллэдэг. Энэхүү хэвлэлийн хурлаар УУЯ-наас тухайн сард хийж гүйцэтгэсэн ажлаа олон нийтэд танилцуулдаг.
		Уул уурхайн сайд, дэд сайд, ТНБД-ын өрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаал / шийдвэр /-ыг ил тод, нээлттэй байдлыг хангаж яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлууна.	Уул уурхайн сайд, дэд сайд, ТНБД-ын төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалыг mm.gov.mn сайтад тогтмол байршуулж байна.
		Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа үхб журам дүрэм, зааварын ил тод нээлттэй байдлыг хангана.	Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх журам дүрэм, зааврын ил тод байдлыг хангаж mm.gov.mn сайтад тогтмол байршуулж байна. Уул уурхайн яамны өвлөгөө авахад

			<p>шаардлагатай 30 бичиг баримтын жагсаалтыг гаргасан. Уг жагсаалтыг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Цахим хуудасны мэдээллийг тухай бүр шинэчлэж байгаа. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа 27 хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын жагсаалт, эмхтгэлийг хэвлэн гаргасан.</p> <p>Яамны үйл ажиллагаандаа мөрдөж байгаа 30 хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын жагсаалтыг цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Мэдээллийг тухай бүр шинэчилж байгаа</p>
15	Иргэдийн өргөдөл/санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн мэдээллийг үлээн авч шалгах	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх хүрээний асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээллэж сурталчилна.	Уул уурхайн яамны үгээс сар бүр хэвлэлийн хурал зохион байгуулахаас гадна хэвлэл мэдээллийн байгууллагынханы сонирхсон сэдвээр нээлттэй ярилцлага, мэдээлэл өгч ажиллаж байна.
		Өргөдөл, гомдол, хүсэлт, х мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлж утас, санал авах хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс ажиллуулна.	Угтах үйлчилгээний ажилтан ажиллуулж иргэдээс өргөдөл гомдол хүлээн авах хайрцаг, 264373 дугаарын утсыг яамны үүдний зааланд байршуулсан.
		Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулна.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулж байна.
		Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, х мэдээллийг шийдвэрлэсэн байдлыг яамны цахим хуудас	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн байдлыг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод, нээлттэй байдлаар тогтмол мэдээллэж байна.

		болон мэдээлийн самбарт ил тод, нээлттэй байдлаар тогтмол мэдээллэнэ.	
16	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	<p>Авлигын эсрэг конвенцийн “авлигад өртөмтгий гэж тооцогдох нийтийн албан тушаал”-д уул уурхайн салбарт ямар ажил, албан тушаал хамааруулах талаарх ойлголтыг тодорхойлох, зохих судалдаал т хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх</p> <p>Уул уурхайн салбарт эрсдлийн удирдлагыг үүлэжэвтр салбарын онцлог чүүрэгтэй уялдуулсан эрсдлийн удирдлагын бодлого, зайны хяналтыг хэрэгжүүлэх шалгуур, системийг боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>Авлигын эсрэг конвенцийн “авлигад өртөмтгий гэж тооцогдох нийтийн албан тушаал”-д уул уурхайн салбарт ямар ажил, албан тушаал хамааруулах талаарх ойлголтыг тодорхойлох, зохих судалдааг төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч тодорхой ажил хийгдээгүй байна.</p> <p>- Хүнд суртал, чирэгдлийг багасгах, өрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын өрч -лийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх зохиолгоор дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Угтах үйлчилгээний ажилтныг томилон ажиллуулж, Төрийн нарийн бичгийн даргын 2013.05.07-ны өдрийн 58 дугаар тушаалаар “Уул уурхайн яамны нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна. - Яамнаас төрийн үйлчилгээ ав ахтай холбогдсон хууль, дүрэм, журмуудыг яамны цахим хуудсанд байршуулсан. - Мөн яамны үүдний фестивльд байршуулсан цахим самбарт болон яамны дотоод сүлжээнд байршуулсан. <p>-Мэдээлийн самбарт тухай бүр тавьж байна.</p> <p>-Албан хаагчдаас ашиг сонирхлын өрчийн мэд үүлгийг хянаж мэдэгдэл гаргаж байна. 2015 онд 26 албан албан хаагч мэдэгдэл гаргасныг цаасаар болон цахимаар бүртгэсэн.</p> <p>-2015 онд 3 албан хаагчийг сэлүүлэн ажиллуулсан. Ашигт малтмалын газраас 1, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газраас 1, Уул уурхайн яамнаас Үндэсний авулгүй байдлын эвлөлд 1 албан хаагчийг тус тус сэлгүүлэн ажиллуулж байна.</p>

		<p>Тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлан Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтийг шинэчлэн гаргана.</p>	<p>Яам агентлагын хэмжээнд Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтийг шинэчлэн гаргасан.</p>
		<p>Эрсдэлтэй ажил, албан тушаал үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилчдын ажиллагааг хянах, үнэлж болломжийг бүрдүүлнэ.</p>	<p>Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргуулан бүртгэж байна. Энэ талаар албан хаагчид з мэдээллийг Е-оффис болон мэдээллийн самбарт тавьж мэдээллэж байна. 2015 онд 26 албан хаагчаас Мэдэгдэл, тайлбарыг гаргуулан авч цаасаар болон цахимаар бүртгэсэн.</p>
		<p>Авлигын эсрэг ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхолын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг тухай үр зохион байгуулна.</p>	<p>УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын дагуу “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийт 60 албан хаагчаас цахимаар болон цаасаар гаргуулан хянаж бүртгэж, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг 18 этгээдээс гаргуулан авч бүртгэн холбогдох материалын хамт АТГ-т хүргүүлэн хянуулж шийдвэрлсэн. “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 26 албан хаагчаас гаргуулан хянаж бүртгэсэн байна. 3 албан хаагч их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн байна. 2014 онд Уул уурхайн яаманд АМГ-аас 2 албан хаагч, ЗГХЭГ-аас 1 албан хаагч, Уул уурхайн яамнаас 1 албан хаагчийг УАБЗ -д Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн дагуу сэлгүүлэн ажиллуулсан.</p>
17	Авлигатай тэмцэх газраас	Авлигатай тэмцэх газраас	Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны 06 дугаар

	бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	ирүүлсэн Зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж биелэлтийг дурьдсан хугацаанд нь АТГ-т хүргүүлнэ.	сарын 17-ны өдрийн 01/4252 д угаартай “Хуулийн хэрэгжилтийг хангуулж, өрчил арилгуулах тухай” албан тоотоорүүлсэн зөвлөмжийн дагуу холдбогдох арга хэмжээг авч Уул уурхайн сайдын 2015 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 1/1718 дугаар тоотоор биеэлэтийг АТГ-т хүргүүлсэн. Албан бичгийн хуулбарыг хавсаргав.
18	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэхүсэл, эрмэлзэл, хүчин чармайлт	Авлигын эсрэгөрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриалгыг дэмжиж ажиллана	“Ил тод байдлыг дэмжихүншлэл” ТББ -ын үлжээ Нийгмийн дэвшил Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ТББ -аас зохион байгуулсан “хуулийн хэрэгжилтийн цуврал үнэлгээ” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон. Төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачлагыг дэмжин ажиллаж байна.
19	Албан хаагчдын шударга байдал үүнийг т нэмэгдүүлэх	Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шударга ёс, ёс үй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцэг, ярилцлага, өдөрлөгийг зохи он байгуулах, харьяа байгууллагуудад өвлөмж өгөх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулна	Төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх цогц сургалтын хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлаар Удирдлагын акапемийн багш нартай хамтран 2015 оны 11үгдэ р сард сургалт зохион байгуулахаар өтөлбөр гарган ажиллаж байна. Яамны албан хаагчдад “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүлэг” болон “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг өрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль болон төрийн албан хаагчийн үй, Харилцааны соёлын асуудлаар шинээр албан тушаалд томилогдсон албан хаагчдад сургалт явуулсан. М AMГ б олон ГТГ-ын ЭБАТ-нуудад ажил өрлийн талаар зөвлөгөө өгч мэргэжил арга үйн туслалцаа үзүүлж байна. Улсын архивынүзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх талаар хэрэгж байгаа арга хэмжээний биелэлтэд шалгалт хийж ХАСХОМ-ийг бүртгэх хадгалах, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх талаар зохион байгуулах ажлын

			<p>талаар өвлөгөө өгсөн. Мөн яамны дотоод нэгжүүдийн удирдлагуудад “Авилаас урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах тухай өвлөмжийг хүргүүлэн 2015 оны авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллганы төлөвлөгөөнд саналыг нь тусган хэрэгжүүлж ажилласан.</p>
20	<p>Орон нутгийн захиргааны байгууллага, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах үйл явцад тавих хяналтыг сайжруулах</p>	<p>Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлж, хуульд нийцүүлэн "Орон нутгийг өгжүүлэх хамтын ажиллагааны гэрээний загварыг баталж хэрэгжүүлэх</p>	<p>Ашигт малтмалын тухайн хуулийн 42 дугаар зүйлд "тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд үндсийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана" гэж заасан.</p> <p>Уул уурхайн яамнаас уг хамтран ажиллах гэрээний загварыг Хоган Ловеллс олон улсын нэр хүнд бүхий хуулийн фирмтэй хамтран боловсруулж байгаа бөгөөд ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд уг загвар гэрээнд зайлшгүй тусгах шаардлагатай орон нутагт тулгарч буй нийтлэг асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохүүднээс Улаанбаатар хот болон Өмнөговь, Төв, Дорноговь аймгуудад хэлэлцүүлэг зохион байгуулаад байна.</p> <p>Хэлэлцүүлэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аймаг, сумдын 150 орчим төлөөлөл, уул уурхайн 60 орчим компаниуд болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон байна.</p> <p>Газрын тосны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан уг хуулийн 7.1.13-т “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн өгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээний загвар”-ыг Засгийн газар батлахаар заасны дагуу гэрээний загварын өслийг “Гэрээний загвар</p>

			батлах тухай” Засгийн газрын тогтоолын хамт боловсруулан Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.
		Аймгийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хуулийн хүрээнд хүнд суртал, чирэгдэлгүй, ил тод үйлчлэх ажлыг зохион байгуулах талаар тусгаж хэрэгжүүлэх	Орон нутгийн захиргааны байгууллагатай байгуулах хамтран ажиллах гэрээний загварыг баталснаар аймаг, сумдууд хуулийн хүрээнд эрх ашгийн өрчилтэй гэрээ байгуулдаг байсныг халж нэгдсэн нэг гэрээний загвартай болох юм. Гэрээний гол агуулгаас дурдвал талуудын эрх, үүрэг, орон нутгийн хөгжлийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, ил тод байдал, үйл ажиллагааг санхүүжүүлэх арга хэлбэр, гэрээний хяналтын үнэ, гэрээний хугацаа болон дүгнэх зэрэг асуудлуудыг тусгасан байна.
21	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга ОУИТБС/ - ыг хэрэгжүүлэгч улс орнуудад тавигдах шаардлагын хүрээнд олон нийтэд нээлттэй кадастр, лицензийн үртгэлийн б мэдээллийн сантай байх энэхүү санд ОУИТБС -ын тайланд хамрагдсан бүх компанийн эзэмшиж буй лиценз болгоны мэдээллийг оруулах	Энэхүү ажлын хүрээнд ОУИТБС-ын ажлын албаны веб сайтад / www.eitimongolia.mn / хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээлэл, тусгай өвшөөрлийн хөдөлгөөний мэдээлэл, шинээр олгогдсон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл олгох талбайн мэдээлэл зэргийг ил тод нээлттэй мэдээлж байна.
		Олборлох салбарын тендерт оролцон, жоронго оруулалт хийн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг корпораци аж ахуйн нэгжийн өлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тухай, тэдний эзэмшлийн хувь хэмжээний мэдээллийг нээлттэй болгох	Олборлох салбарт үйл ажиллагаа эрхлэн явуулдаг аж ахуйн нэгж байгууллагын хувьцаа эзэмшигчдийн тухай, тэдний хувь хэмжээний талаарх мэдээллийг нээлттэй ил тод байлгах зорилгоор УИХ-ын ЭЗБХ-нд хэлэлцэгдэж байгаа “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль”-ийн өслийн 11 дүгээр зүйлийн 11.5.4 дэх хэсэгт тусгасан.
		Ашигт малтмал, байгалийн хий,	ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 12 дугаар

		<p>газрын тос олборлохоор хийсэн бүх гэрээ, гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг нээлттэй болгох</p>	<p>хуралдааны 2015 оны 1 дүгээр сарын 13 -ны өдрийн хуралдааны шийдвэрийн 1.3 дахь хэсэгт 5-н дэд ажлын хэсэг байгуулах шийдвэр гаргасан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Уул уурхайн салбарын орлогыг тусад нэрлэх асуудлаар, 2.Байгаль орчныг өмнө сэргээх барьцаа төлбөр, мониторинг хийх асуудлаар, 3.Аудитын нэгтгэлийн үеэр аудитын байгууллагад гаргах шаардлагатай мэдээллийн жагсаалт боловсруулж, түүнийг нэг стандарт, маягтад оруулах асуудлаар, 4.Эрдэс баялгийн салбарт байгуулагдсан гэрээ, түүний ач холбогдлыг судлах асуудлаар, 5.Уул уурхайн салбарын эхний топ 10 аж ахуйн нэгжүүдэд хууль жигд үйлчлэх асуудлаар. <p>Үүнээс 4 дүгээр ажлын хэсгийн хүрээнд Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангахад тулгарч буй бэрхшээл, талуудын байр суурь, ил тод болгосноор бий болох ач холбогдол, үр нөлөөг судлах чиглэлээр ажлын хэсэг ажиллаж</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хөрөнгө оруулалтын гэрээ /уул уурхайн салбарт/ ➤ Тогтвортой байдлын гэрээ /уул уурхайн салбарт/ ➤ Бүтээгдэхүүн хуваах гэрээ /газрын тосны уламжлалт салбарт/ ➤ Бүтээгдэхүүн хуваах гэрээ /газрын тосны уламжлалт бус салбарт/ ➤ Концессын гэрээ /дэдүтэц/ зэргээр судалгаа хийж ил тод болгох асуудлыг хэлэлцэн Нээлттэй нийгэм форум өрийн бус байгууллагаар вэб сайт хийлгэх ОУИТБС-ын ажлын албаны сайтад тусад нь байршуулж мэдээллийг ил тод болгохоор шийдвэрлэсэн.
		<p>Олборлох салбараас үлээм авсан орлого болон ашигт</p>	<p>Олборлох салбараас үлээн авсан орлого болон ашигт малтмал, газрын тос байгалийн хий олборлож</p>

	малтмал, газрын тос, байгалийн хий олборлож буй компаниас төрд төлсөн төлбөрийг ил тод нээлттэй мэдээлэх, өн төлбөр төлж буй компани нь эдгээр төлбөрийн талаарх мэдээллийг ил болгох	буй компаниасөрд төлсөн төлбөрийг ил тод нээлттэй мэдээлэх, мөн төлбөр төлж буй компани нь эдгээр өлбөрийн талаарх мэдээллийг ил болгох асуудлыг Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд тусгасан.
--	--	--

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛИЙГ НЭГТГЭЖ ГАРГАСАН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Ж.ДЭМЧИГСҮРЭН